

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Хоол хүнсний материалын техникийн тодорхойлолт

Багц-1 Мах, махан бүтээгдэхүүн	Үхрийн мах	MNS 5023:2001 стандартын шаардлага хангасан 1 ба 2-р зэргийн мах байна. Малын гарал үүслийн гэрчилгээтэй, махны тод улаан өнгөтэй, гадаргуу цэвэр хуурай, горимын дагуу загсаасан, уян харимхай, хуруугаар дарсан хонхорхой арилдаг, өөх нь цагаан шаргал, хатуу, ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангасан, мал эмнэлгийн шинжилгээний дүгнэлттэй байх. /илчлэг сайтай тарганмалын мах нийлүүлэх/
	Хонины мах	
	Дайвар	
Багц-2 Талх нарийн боов	Талх, Төрөл бүрийн нарийн боов	Бүтээгдэхүүний чанар, хэлбэр, өнгө гадаргуу, амт үнэр зэрэг стандартын шаардлага хангасан үйлдвэрт баталгаажсан жор технологийн зааврыг баримтлан үйлдвэрлэсэн байх ба Дархан Хүнс ХК-ны үйлдвэрийн бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц байх /Дээж ирүүлнэ/
Багц-3 Сүү, сүүн бүтээгдэхүүн	Сүү	MNS 5547-2008, MNS 219-79 стандарт шаардлага хангасан. Чанарын аюулгүй байдал хангасан, MNS 4229- 2005 стандартын шаардлага хангасан. Цагаан өнгөтэй, жигд шингэн бие бүтэц өөрийн өвөрмөц амт үнэртэй, гадныдагалдах амт үнэргүй, тослог хүчиллэг зөвшөөрөгдөх хэмжээнд гурилын болон усны хольцгүй байна. Монгол малын сүү байх. Мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээний дүгнэлттэй байна.
	Аарц	Шаргал өнгөтэй, исгэлэн амт үнэртэй, өтгөвтөр бие бүтэцтэй, гадны хольц, амт үнэргүй MNS 4551:93 стандартын шаардлага хангасан байна. Мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээний дүгнэлттэй байна /Шахсан хольцгүй/
Багц-4 Хүнсний ногоо	Төмс	Эх орны хөрсөнд тариалсан, эрүүл ахуйн шаардлага хангасан, ялзарч гэмтээгүй хадгалалтын горим мөрдсөн, /орон нутгаас бэлтгэх/,Төмс- Гадаад байдал нь бүтэн сортынхоо хэлбэр дүрсийг хадгалсан, хөнөөлт шавьжаар гэмтээгүй, бүтэн, хуурай, хөндлөн огтлолын өнгө цагаан шар, хальсны бэхжилт сайн, Байцаа-Сортынхоо хэлбэрийг хадгалсан, гадны амт үнэргүй, хөнөөлт шавьжинд идэгдээгүй, хөлдөлт хайрагдалтгүй, өнгө цайвар ногооноос цагаан байх. Лууван: Сортынхоо хэлбэр дүрсийг хадгалсан, өнгө жигд улаан шаргал, гадны амт үнэргүй, хортонд гэмтэж өвчлөөгүй, дотроо хөндийрөөгүй, өлсөж үрчийгээгүй байх шаардлагатай. Сонгино: Сайн сортын хэлбэр дүрсээ хадгалсан,бөөрөнхий хэлбэртэй, гадаргуу хуурай, өвчлөлтгүй, хөндлөн огтлол дахь өнгө цагаан шар, механик гэмтэлгүй байх.Хүнсний ногоог зориулалтын зооринд стандартын дагуу хадгалсан байх
	Лууван	
	Манжин	
	Байцаа	
	Сармис	
	Сонгино	

Багц- 5 Гурилан бүтээгдэхүүн	Гурил	MNS 0244:2009 буудайн гурил. Техникийн ерөнхий шаардлага хангасан. Исгэлэн хөгцөрсөн үнэргүй, гашуун эсвэл чихэрлэг амтгүй, шинэхэн буудайн үнэртэй байна. Улаанбаатар үйлдвэрийн 1-р гурилтай дүйцэхүйц байна.
	Цагаан будаа	MNS ISO 7301:2000 стандартын шаардлага хангасан. Эрүүл ахуйн шаардлага хангасан. /25 кг-ын савлагаатай, сайн чанарын ОХУ-д үйлдвэрлэгдсэн будаатай дүйцэхүйц/
	Шар будаа	MNS 0533:1998, ГОСТ 572-60 стандартын шаардлагыг хангасан. / сайн чанарын ОХУ-д үйлдвэрлэгдсэн будаатай дүйцэхүйц/
	Хөц будаа	MNS 4515:2010, ГОСТ 5784-60 стандартын шаардлагыг хангасан./ сайн чанарын ОХУ-д үйлдвэрлэгдсэн будаатай дүйцэхүйц/
	Каш	MNS 0243:2003 стандартын шаардлагыг хангасан. / сайн чанарын ОХУ-д үйлдвэрлэгдсэн слава будаатай дүйцэхүйц /
	Овьёос	MNS 6511:2015 стандартын шаардлагыг хангасан. / сайн чанарын ОХУ-д үйлдвэрлэгдсэн будаатай дүйцэхүйц/
	Гоймон	Алтан тариан Лапша гоймонтой дүйцэхүйц, сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн / MNS 142-85 хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторын ундны ус хүнсний хими хор судлал хөгц мөөгөнцөр хүнд металлын лабораторын 15340-15346 тоот шинжилгээний дүнгийн тэмдэглэлтэй..
	Гурвалжин будаа	MNS 4293-95 гадаад хэлбэр дүрс цэцгийн хайрснаас салгаж цэвэрлэсэн гурвалжин будааны гурван талт самранцар үртэй байна энэ нь шаардлагад нийцсэн .
	Хүүхдийн будаа каша	MNS 6308:2012 стандартын дагуу хүнд металлын үлдэгдэл тодорхойлох шинжилгээгээр кадми 0,001 мг/кг хар тугалга 0,001 мг нян судлалын шинжилгээгээр 0,1 гр мл-д колиформ 25 гр-/мл-д салмонелл хор судлалын шинжилгээгээр афлатоксин В1,В2 тус тус илрээгүй
	Овьёос	Геркулес нь MNS 4293-95 гадаад хэлбэр дүрс цэцгийн хайрснаас салгаж цэвэрлэсэн гурвалжин будааны гурван талт самранцар үртэй байна энэ нь шаардлагад нийцсэн.
	Аньс	Стандартын шаардлага хангасан, гарал үүслийн гэрчилгээ шинжилгээний дүгнэлттэй байна. /Шингэн, өтгөрүүлсэн/
	Чацаргана	
	Нэрс	
	Масло	MNS 2842:1981, MNS 4505:2008 стандартын шаардлагыг хангасан, цайвар шаргал өнгөтэй, нэр төрөлдөө тохирсон үнэр амттай, гадны механик хольцгүй, нян хөгц, мөөгөнцөр илрээгүй байна./тослог өндөртэй 20 кг-ын савлагаатай ОХУ-н янта маслотай дүйцэхүйц/

Багц-6 Бусад хүнсний материал	Ургамлын тос	MNS CAC 125:1998 ГОСТ Р 53510-2009 шаргал өнгөтэй, нэгэн төрлийн бие бүтэцтэй булингар, тунадас үүсээгүй, хөлдөөгүй байна. /1 литрийн савлагаатай тослог ихтэй сайн чанарын /
	Сахар	MNS CAC 212:2014 стандартын шаардлагыг хангасан. Чийггүй бөөгнөрч хатуураагүй шарлаагүй байна./25, 50 кг-аар савласан сайн чанарын ОХУ-д үйлдвэрлэгдсэн элсэн чихэртэй дүйцэхүйц/
	Исгэгч	Сав баглаа боодол бүрэн бүтэн. /100 гр-ын савлагаатай Ангел исгэгчтэй дүйцэхүйц/
	Цай	/1кг-ын савлагаатай Найман гишүүн төгөлдөр цайтай дүйцэхүйц/
	Сода	/500 гр-ын савлагаатай ОХУ-д үйлдвэрлэгдсэн содатай дүйцэхүйц/
	Давс	1 кг-ын савлагаатай, иоджуулсан эко нуурын давстай дүйцэхүйц /
	Варень	Варень MNS 6308 :2012 стандартын дагуу нэрсний чанамал гүзээлзгэний чанамал,аньсны чанамал,үхрийн нүдний чанамал
	Үзэм, хар чавга, чангаанз	Сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн. / MNS 2782:1:2014 гадаад хорио цээртэй хортон шавьж, MNS 2782:2:2014 хачиг 2292-2301 /
Печень	Сайн чанарын, дотоод, гадаадын үйлдвэрийн эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн	

